



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2022.06.17 № 30

Хүн амын нийтийн эрүүл мэндийн  
талаар авч хэрэгжүүлж буй  
арга хэмжээний тухай

Сүүлийн жилүүдэд нийгэм, хүрээлэн буй орчны нөхцөл, иргэдийн амьдралын хэв маяг, хоол хүнсний чанар, аюулгүй байдал доройтсонтой холбогдуулан хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихсэж байна. Манай улсад хүн амын нас баралтын үндсэн шалтгаан нь : 5 хүртэлх насны хүүхдүүдэд амьсгалын замын өвчин, суулгалт, халдвар, насанд хүрэгчдэд зүрх судасны өвчин, хорт хавдар, осол гэмтэл орж байна. Халдварт бус өвчний шаталсан судалгаагаар судалгаанд хамрагдсан 15-64 насны 10 хүн тутмын (90.6%)-д халдварт бус өвчний нийтлэг эрсдэлийн ямар нэг хүчин зүйл илэрч, 5 хүн тутмын 1-д 3-аас дээш эрсдэл хавсарсан байдлаар нөлөөлж, 45-аас дээш насны 2 эрэгтэй тутмын 1-д (архидах, тамхидах, таргалалт гэх мэт) өвчлөх эрсдэлийн хүчин зүйлүүд өндөр байна.

Мөн үүний зэрэгцээ Монгол Улсын хүн амын дунд бүртгэгдсэн хорт хавдрын шинэ өвчлөлийн тоог сүүлийн хоёр жилээр харахад, 2020 онд 6702, 2021 онд 5981 тус тус бүртгэгдсэн байна. Зонхилон тохиолдох эхний 5 байрлалын хорт хавдрын өвчлөлийн бүтцэд элэгний хорт хавдар 32.7 хувь, ходоодны хорт хавдар 16.1 хувь, уушги гуурсан хоолойн хорт хавдар 7.5 хувь, улаан хоолойн хорт хавдар 5.7 хувь, умайн хүзүүний хорт хавдар 5.2 хувийг тус тус эзэлж байна.

Монгол Улс нь хорт хавдрын өвчлөлөөр элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтаар нэгдүгээрт, ходоодны хорт хавдар хоёрдугаарт орж байгаа бол нийт хорт хавдрын шалтгаант нас баралтаар нэгдүгээрт, элэг, ходоодны хорт хавдрын нас баралтаар хоёрдугаарт, улаан хоолойн хорт хавдрын нас баралтаар гуравдугаарт жагсаж байна. Жилд оношлогдож буй хорт хавдрын 72.4 хувь нь хожуу үе буюу 3-4 үе шатандаа төгс эмчлэгдэх боломж багассан үедээ оношлогдож байгаагаас нас баралтын түвшин өндөр байгаа тул иргэдээс халдварт бус өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах тогтолцоог бэхжүүлэх, нийгмийн эрүүл мэндийн боловсрол, чанар хүртээмжийг сайжруулах, илүүдэл жингээс сэргийлэх, хоол, хүнсний зохистой хэрэглээний тухай сургалт, мэдээлэл олгох ажлыг зохион байгуулах хүсэлтүүдийг Монгол Улсын Их Хурлын гишүүн надад ирүүлж байна.

Иймд миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 13 дугаар зүйлийн 13.1-д тус тус заасныг үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1-т “Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоонд хамрагдах, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу өнгөрсөн 2020-аас 2022 оны эхний хагас жилийн хугацаанд улсын хэмжээнд хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, төсвийн зарцуулалт, үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

2. Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.1-т “Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ” гэж заасны дагуу өнгөрсөн 2020-аас 2022 оны эхний хагас жилийн хугацаанд улсын хэмжээнд хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ, төсвийн зарцуулалт, үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

3. “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

4. Нийт иргэдийн дунд таргалалт, илүүдэл жин ямар түвшинд ямар хэмжээнд байгаа эсэх, илүүдэл жин нь иргэдийн эрүүл мэндэд хэрхэн сөргөөр нөлөөлж ямар ямар өвчний эх үүсвэр болж байгаа талаар, иргэдийн дунд илүүдэл жингээс болж үүсэж болох эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр цаашид ямар бодлого баримталж буй талаар;

5. Нярай болон бага насны хүүхдийг халдварт бус өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хянах тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ, цаашид баримталж буй бодлогын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

6. Хавдрын эсрэг тэр дундаа хүүхдийн хорт хавдартай тэмцэх хүрээнд хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл болон өнөөдрийг хүртэлх хугацаанд хорт хавдар өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, цаашид баримталж буй бодлогын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

7. Дээрх асуултуудад дурдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр зорилтот үр дүнд хүрч буй эсэх, хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх арга замын талаар тодорхой санал зэрэг болно.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлэх, цаашид 2022 оны Улсын Их Хурлын намрын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Б.БАЯРСАЙХАН

2022000074